



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2021.05.05

№ 70/21-04

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 60.2, 60.3, 76.1.2 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39/2 байр, “Велокс” оффисын байранд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

- Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 онд хийсэн ажлын танилцуулга
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай
- Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай
- “Ногдол ашиг хуваарилах эсэх тухай” 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн 01 тоот тогтоол танилцуулах

3. Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батхуягийг, хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнг томилсугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хурлын зарыг 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын сониноор хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хурлын зар мэдээг анхны мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа өмнө нь мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2, “Велокс” оффис-ын 8 давхарт болон Хөвсгөл аймгийн Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцаж болохыг дурьдсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2021 оны 03 дугаар сарын 14-ны өдрөөр тогтоосугай.

Алтан
дуулга

9. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт, хэлэлцэх асуудлаар санал өгөх "Саналын хуудас"-ны агуулгыг 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн урьдчилж өгөх саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11:00 цаг байхаар тогтсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар "МКМ" ХХК-ийн захирал Т.Жавзанжимдаан, гишүүдээр тус компанийн ажилтан Х.Гэрэлт-Од, Т. Цогбаатар нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН ҮДИРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Д. БАТХУЯГ





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн То/21-07 тогтоол
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
4. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын тайлан
5. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл №01
6. Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 онд хийсэн ажлын танилцуулга
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай тогтоолын төсөл №02
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай тогтоолын төсөл №03
9. Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай танилцуулга, тогтоолын төсөл №04
10. “Ногдол ашиг хуваарилах эсэх тухай” ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот тогтоол
11. Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилт болон санхүүгийн төлөвлөгөөний талаар хураангуй танилцуулга
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн нэр	Тогтоолын төсөл
“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн То/21-07 тогтоол	№07
Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	№08
Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан	№09
Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын тайлан	№10
Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл №01	№01
Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 онд хийсэн ажлын танилцуулга	№02
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай тогтоолын төсөл №02	№02
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай тогтоолын төсөл №03	№03
Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай танилцуулга, тогтоолын төсөл №04	№04
“Ногдол ашиг хуваарилах эсэх тухай” ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот тогтоол	№05
Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилт болон санхүүгийн төлөвлөгөөний талаар хураангуй танилцуулга	№06
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”	№012

Тангариу...

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн
 ТУЗ-ийн 2021 оны 04 дүгээр сарын
 тогтоолын 02 дугаар хавсралт

**“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ
 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРЛОЦОГЧДООС
 САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчдийн овог нэр
 Регистрийн дугаар.....
 Санал өгөх хувьцааны тоо
 Үйлчилсэн / Үнэт цаасны компани /
 Брокерын овог..... нэр.....

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39/2 байр, “Велоке” оффисын байранд болно.

№	Хэлэлцэх асуудал	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн	Татгалзсан	Татгалзсан бол таны өгөх санал
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцах материалд хавсаргасан. №01				
2	ТУЗ-ийн 2020 онд хийсэн ажлын танилцуулга	шийдвэр гарахгүй танилцуулах				
3	ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг хэлэлцэн, батлах тухай	Тогтоолын төсөл №02				
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай асуудлыг хэлэлцэх батлах	Тогтоолын төсөл №03				
5	Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай асуудлыг хэлэлцэн, батлах тухай.	Тогтоолын төсөл №4				
6	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн 2021 оны 01 тоот тогтоолыг танилцуулах	Шийдвэр гарахгүй танилцуулах				

(Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү)
 Хувьцаа эзэмшигч..... Гарын үсэг
 2021 оны сар өдөр

Санал авах хуудсыг ашиглах санамж: Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр ирж хуралд оролцох боломжгүй бол 2021 оны 04-р сарын 14-ний 11:00 цагаас өмнө “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн УБ хот болон орон нутгийн байранд эсвэл зуучлагч ҮЦК дээрээ очиж, хурлын материалтай танилцан санал авах хуудсаар саналаа өгнө. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн хүндээ итгэмжлэл өгч нотариатаар батлагаажуулсан байна. Засварласан болон балласан санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39/2 байр, “Велокс” оффисын байранд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосон болно.

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 онд хийсэн ажлын танилцуулга
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай
- Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай
- “Ногдол ашиг хуваарилах эсэх тухай” 2021 оны 02 дугаар сарын 18 ны өдрийн ТУЗ-ийн 01 тоот тогтоол танилцуулах

Хувьцаа эзэмшигч та өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж нотариатаар баталгаажуулсан байна. Саналын хуудсаар урьдчилж саналаа өгөх бол өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани эсвэл компанийн УБ хот болон орон нутаг дахь доор дурьдагдсан хаягаар 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11:00 цагаас өмнө өгнө.

Хурлын материалтай www.altanduulga.mn цахим хуудаснаас болон ажлын өдрүүдэд 10⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2, “Велокс” оффисын 8 давхарт болон Хөвсгөл аймгийн Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцах боломжтой.

Холбоо барих утас: Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Дуламсүрэн утас: 99119138, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Оюунгэрэл утас: 99165186, цахим шуудангийн хаяг: khuvs gul_altanduulga@yahoo.com “Хөвсгөл алтандуулга” ХК утас: 77116031, 70386031

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС